



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 20

- 1. “Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2023.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 5 - 20
-

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 11 дүгээр сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 32 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жавхлан, Д.Өнөрболор;

Чөлөөтэй: Т.Доржханд, Ч.Хүрэлбаатар, С.Чинзориг.

Нэг. “Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа 2023.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Эдийн засгийн зөвлөх Р.Даваадорж, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Долгорсүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн Бизнесийн үйл ажиллагаа, хөгжлийн газрын захирал Б.Батсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Н.Ганибал, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Д.Батлут, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Долгорсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: “Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 9
Бүгд: 13
30.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 49 минут үргэлжилж, 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 32 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан гишүүн гадаадад томилолттой ажиллаж байгаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн орон нутагт ажиллаж байна. Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хоёр. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нарын 4 гишүүн 2022 оны 04 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Хоёр асуудал хэлэлцэхээр товлогдсон байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр Та хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хуулийн төслийнхөө талаар санал хэлнэ үү?

Б.Баттөмөр гишүүний микрофоныг нээнэ.

Б.Баттөмөр: Банк бус санхүүгийн байгууллагын хуульд шинэчилсэн найруулгыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурлаас ажлын хэсэг байгуулсан. С.Чинзориг гишүүнээр ахлуулсан.

Тэгээд өчигдөр ажлын хэсэг хуралдаад, хууль маань 31 орчим заалттай, 24, 25 зарчмын зөрүүтэй саналтай байсан.

Тэгээд ер нь гишүүдээс буцаая гэсэн санал гаргасан.

Тэгээд бид ярьж байгаад долоо хоногийн хугацаатай үүнийг дахиж

боловсруул. Тэгээд долоо хоногийн дараа ажлын хэсэг хуралдъя гээд өчигдөр ажлын хэсэг хуралдаагүй.

Тийм учраас энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлаас хасаж өгнө үү гэсэн тийм саналыг гаргаж байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гишүүн Б.Баттөмөр гишүүний гаргасан

хүсэлтийн дагуу энэ асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаас хасъя. /алх цохив/

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе.
Хэлэлцэх асуудал.

Нэг. “Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа 2023.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нэг. “Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлъе.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа танилцуулна.

Гишүүний микрофоныг нээнэ үү. Ажлын хэсэг. Мэдээлэл өгөх албаныхан орж ирж байна уу? Бэлдэж байгаарай. Ш.Адьяа гишүүний микрофоныг нээнэ үү.

Ш.Адьяа: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

“Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмших тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан.

Тогтоолын төслийг өнөөдөр Эдийн засгийн Байнгын хороогоор хэлэлцэж байна.

Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш шударга, хүртээмжтэй хуваарилах, ил тод, байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын үндсэн хуулийн 6.2, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39, 2012 оны 16, Засгийн газрын 2011 оны 98, 2012 оны 116 дугаар тогтоолуудыг тус тус удирдлага болгон энэ тогтоолын төслийг өргөн барьсан юм.

Монгол Улсын Засгийн газар 2012 онд “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн нийт хувьцааны 20 хувь болох 3 тэрбум ширхэг хувьцааг 2012 оны 04 сарын 01-нээс өмнө төрсөн иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэн бүрд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Эрдэнэс Тавантолгойн нийт хувьцаа 15 тэрбум ширхэг хувьцаатай байгаа.

Тухайн үеийн Засгийн газраас 1072 ширхэг хувьцааг 1 сая төгрөг буюу нэг ширхэг хувьцааны нэрлэсэн үнийг 933 орчим төгрөгөөр үнэлж тооцсон байдаг.

Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 536 ширхэг хувьцаа, мөн Засгийн газрын 2012 оны 04 сарын 11-ний өдрийн 116 дугаар тогтоолын дагуу 530.6 ширхэг хувьцааг нэмж эзэмшүүлэхээр болсон байна.

Засгийн газрын 98 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Улсын бүртгэлийн ерөнхий газрын шинэчилсэн бүртгэлд хамрагдсан 2011 оны 04 сарын 01-нээс өмнө төрсөн Монгол Улсын бүх иргэнд “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 536 ширхэг хувьцааны бичилтийг Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв 2010 онд гүйцэтгэсэн байдаг.

2011 оны 11 дүгээр сард Улсын Их Хурлаас 57 дугаар тогтоол батлахдаа хувьцааг олон улсын зах зээл дээр нээлттэй арилжиж эхлэх хүртэл компаниудын болон иргэдийн хувьцааг зөвхөн Засгийн газар л нэрлэсэн үнээр нь буцааж авч болно гэсэн заалттай байна. Энэ тогтоолоор иргэд хувьцаагаа арилжаалах боломжгүй болсон гэсэн үг ээ.

Одоогоор 1072 хувьцааны дотоодын зах зээл дээр хараахан арилжаалагдаж эхлээгүй байгаа учир өвлөх, шилжүүлэх, бэлэглэх, зарах болон худалдан авах эрхүүд хаалттай байна.

2012 оны Засгийн газрын 116 дугаар тогтоолоор дээрх хувьцааг авсан иргэдэд нэмж 536 ширхэг хувьцааг нэмж

эзэмшүүлэхээр Хүний хөгжил сангаас хишиг хувийг бэлэн мөнгөөр авах хүсэлт гаргасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2010-2011, 2011-2012 оны хичээлийн жил сургалтын төлбөр хэлбэрээр хишиг хувь хүртсэн оюутан, 2011 онд Эрүүл мэндийн даатглайн шимтгэл хэлбэрээр хишиг хувь хүртсэн иргэний өмнө ногдох хувьцааг хасаж тооцсон байна.

2016 онд “Сайн хувьцаа” нэрээр Засгийн газар иргэдийн хувьцааг эргүүлэн худалдаж авсан.

Одоо тус компанийн нийт хувьцааны 14.7 хувь нь иргэдийн мэдэлд, 85.5 хувь нь Засгийн газрын мэдэлд, 0.5 хувь нь аж ахуйн нэгжүүдэд ногдож байна.

2016 оны сонгуулийн өмнө 300 мянган төгрөг авсан иргэдийн хувьцаа 750 ширхэг болсон.

Ер нь Засгийн газар иргэдэд өгсөн 20.0 хувийн эзэмшлийн хувьцааныхаа 6.3 хувийг нь буцааж худалдаж авсан тооцоо байна.

Гэвч үе үеийн эрх баригчид Улсын Их Хурлын сонгуулийн өмнө иргэдийн санал авах хэрэгсэл болгон ашиглаж байсан явдлыг залруулж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга, хүртээмжтэй хуваарилах, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг боловсруулсан болно.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Ц.Цэрэнпунцаг: Тогтоолын төсөлтэй холбогдуулан мэдээлэл авах зорилгоор Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа холбогдох байгууллагын албан тушаалтнуудын нэрсийг нь танилцуулъя.

Э.Батболд Уул Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга, Х.Мөнхжаргал “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Э.Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга, Г.Гантулга “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Р.Даваадорж Улсын Их Хурлын Ардчилсан намын бүлгийн эдийн засгийн зөвлөх, Б.Долгорсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ж.Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, А.Нинжин Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх, Б.Батсүрэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Бизнесийн үйл ажиллагаа, хөгжлийн газрын захирал.

Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү?

Т.Энхтүвшин гишүүн байна. Өөр гишүүд байна уу? Н.Ганибал гишүүнээр тасаллаа.

Т.Энхтүвшин гишүүний микрофоныг нээнэ үү?

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Д.Батлут гишүүнээр уг нь ахлуулсан нэг ажлын хэсэг ажиллаж байх ёстой юм.

Ш.Адъяаа гишүүн ээ.

Тэгээд ямар ажлын хэсэг вэ гэхээр нэгдүгээрт төрийн өмчтэй компани, орон нутгийн өмчтэй компанийн менежментийг сайжруулах, хувьцааг нээлттэй худалдаалах, олон нийтийн болгох, дахин төрийн өмчтэй болон орон нутгийн өмчтэй компанийг дахиж төр байгуулахгүй байх тухай ийм ажлын хэсэг Д.Батлут гишүүн дээр ажиллаж байгаа.

Тийм учраас энэ Улсын Их Хурлын тогтоолоо татаж аваад эргүүлээд Д.Батлут гишүүний тэр ажлын хэсэг дээр нь зангидаад дахин боловсруулаад оруулж ирвэл яасан юм бэ гэдэг саналыг хэлж байгаа юм.

Яагаад гэхээр таны тогтоолын төслийг харахаар 2012 онд төр худалдаад авчхаж байгаа юм. Тэгэхдээ иргэдийн өөрсдийнх нь санаачилгаар шүү дээ.

Төр худалдаж авчхаад, төр тодорхой хэмжээний юу гэдэг юм мөнгө гаргаад худалдаад авчихсан. Тэгээд хэсэг хугацааны дараа сонгуулийн өмнө иргэдээс нь өөрсдөөс нь асуухгүйгээр хувьцааг нь нэмж олгоё гэдэг асуудал тавиад орж ирж байгаа нь өөрөө их зохимжгүй байна. Энэ чинь боллоцоо боломжгүй асуудал байна.

Тэгээд ганцхан энэ “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотой асуудлыг ингэж энэ дээр яримааргүй байна.

Хэрвээ ярих гэж байгаа бол Монгол Улсад байж байгаа бүх төрийн өмчтэй компанийн хувьцааны асуудал, олон нийтийн болгох асуудал, бүх орон

нутгийн өмчит компаниудыг олон нийтийн болгох асуудлыг нэг мөр оруулж ирээд явбал илүү их тодорхой болох юм биш үү.

Энэ бол одоо зүгээр л нэг сонгуулийн шоу болсон. Сонгуулийн юугаар нэг оноо авах гэсэн нэг ийм л тогтоолын төсөл байна. Би сая л уншиж үзлээ л дээ.

Тэгэхээр үүнийг Та бас нэг эргэж хараад энэ дээр юу гэдэг юм тэр ажлын хэсэг дээрээ зангидаад нэгдсэн ойлголттой болоод ингээд Монгол Улсын хэмжээгээр нь энэ тогтоолын төслөө оруулж ирвэл яасан юм бэ гэдэг дээр би ийм саналтай байна.

Дээр нь энэ “Эрдэнэс Тавантолгой”-н хүмүүс ирчихсэн байна. Яг тэр үед хэчнээн иргэдээс худалдаж авч байсан юм? Тэтгэврийн насны хэдэн иргэдээс авч байсан юм? Оюутан хэдэн иргэдээс авч байсан юм? Өөрсдөө санаачилгаараа өгсөн хэдэн иргэн байгаа юм? Хэдэн төгрөгийн хувьцаа байгаа юм? 1072 хувьцааг хэдэн төгрөгөөр худалдаж авсан гэдэг дээр нэг мэдээлэл өгөөдхөөч. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн санал хэлээд дараа нь тодорхой асуултууд асуусан.

Асуултад ажлын хэсгээс хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 3 номер. 3 номерын микрофоныг нээнэ үү.

Б.Долгорсүрэн: Өнөөдрийн байдлаар бидэнд байгаа тоогоор **ахмад настан** хишиг бүрдсэн иргэдийн тоо **322 мянга 767**, **хөгжлийн бэрхшээлтэй** иргэд **1721**, 2011 оны **эрүүл мэндийн даатгалын шимтгэл** хэлбэрээр суутгуулсан **615 мянга 701** иргэн, 2011, 2012 онд **оюутны**

сургалтын төлбөрт зарцуулсан **278 мянга 258**, 2016 онд хэрэгжүүлсэн “**Сайн хувьцаа**” хөтөлбөрт нийт **1 сая 294 мянга 302**, өнөөдрийн байдлаар нийт **2 сая 512 мянга 779** иргэн давхардсан тоогоор ямар нэгэн хэмжээгээр хувь хишиг хүртсэн байдаг.

Эдгээрийн нийт дүн өнөөдрийн байдлаар **826.0 тэрбум** төгрөгийн **хишиг** хүртсэн байгаа. Мөнгөн дүнгээрээ **826 тэрбум 927 сая 160 мянга 716** төгрөг. Яг тодорхой хэлбэл.

Нийт **886 сая 309 мянга 923** ширхэг хувьцааг **төр буцааж худалдаж авчихсан байгаа** гэсэн үг. Яг тоогоороо.

886 сая 309 мянга 923 ширхэг хувьцааны асуудал яригдана. Эрдэнэс Тавантолгойн.

Ц.Цэрэнпунцаг: Нийт хувьцааны тоо хэд юм?

Б.Долгорсүрэн: Нийт хувьцааны тоо **12 тэрбум хувьцаа** гаргаснаасаа **886 сая 309 мянга 923-ыг** нь төр худалдаад авчихсан гэсэн үг.

Ц.Цэрэнпунцаг: Төсөл санаачлагч Ш.Адьяаа гишүүн хариулъя. Ш.Адьяаа гишүүний микрофоныг нээе.

Ш.Адьяаа: Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Харамсалтай байна, Т.Энхтүвшин гишүүн ээ,

Дорноговь аймгийн сонгогчид болон Монголын ард иргэдийг өмч хөрөнгөтэй байна гэдэг юмыг санаачлахаар сонгуулийн өмнө ийм юм хийж байна гэдэг байр суурь илэрхийлж байгаад туйлын харамсаж байна.

Үе үеийн эрх баригчид Улсын Их Хурлын сонгуулийн өмнө иргэдийнхээ өмч хөрөнгөтэй байх байдалд сонгуульд санал худалдаж авах зорилгоор **хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд, оюутнуудын хувьцааг** мөнгөн хэлбэр, мөнгө өгөөд авчихсан.

Тэгээд үүнийг өнөөдөр буцаагаад өгчихөөр яагаад болохгүй байгаа юм. Бид нар үнэ төлбөргүй авъя гээгүй шүү дээ. Үүнийг тэр ногдол ашгаас нь суутгаад авчихъя.

Тэгэхээр төрд ч дарамт алга, бусад эдийн засгийн дарамт байхгүй л гэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг сонгууль энэ тэр гэж ийм юм ярьж байгаад их харамсаж байна шүү Т.Энхтүвшин гишүүн ээ.

Надад тийм сонгууль энэ тэр бодсон юм байхгүй ээ.

Ер нь өнөөдөр төрийн өмч хөрөнгө үнэгүйддэг, хяналтгүй болдог, тэгээд компанийн засаглал байхгүй, дампуурсан байдалд иргэдийн оролцоог, иргэдийн хяналтыг л сайжруулъя гэж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасан иргэн бүр өмч хөрөнгөтэй байх, газрын хэвлийн баялгаа ашиглах зарчмыг л биелүүлье гэж байгаа юм.

Үе үеийн Улсын Их Хурал, 2012 онд Монгол Ардын нам төр барьж байсан. 2016 онд Ардчилсан нам төр барьж байсан.

Энэ үед зөвхөн сонгуулийн өмнө сонгууль болохоос нэг сарын өмнө энэ ард түмнийхээ мэдээлэл дутуу, хөрөнгө мөнгөгүй байдлыг далимдуулж

сонгуульд санал авах зорилгоор хийсэн юмыг л залруулъя л гэж байгаа шүү дээ.

Түүнээс биш миний, хөөрхий дөө би сонгуульд санал авах гэж юу ярих вэ дээ, Т.Энхтүвшин минь. Тэгээд энд бас би ярьсан юмыг чинь авах, гээхийн ухаанаар хандаж байна.

Тэгэхдээ энэ асуудлыг цаашлаад Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь шийдээд, цаашлаад тэр Д.Батлут гишүүний бусад асуудалтай нэгтгээд хэлэлцээд явахад миний зүгээс татгалзах зүйл байхгүй ээ.

Энд би ямар нэгэн тийм оноо авах гэсэнгүй. Ард түмнээ өмч хөрөнгөтэй байлгая. Тэр стратегийн ордуудад байгаа асуудалд ард түмний оролцоо, хяналтыг сайжруулъя гэж байгаа шүү дээ.

Өнөөдөр сая гаруй хүний хувьцааг нь буцаагаад авчихсан байна лээ шүү дээ. Энэ мэдээллээр. Нэмж манай бүлгийн зөвлөх Р.Даваадорж хэдэн хүн ямар хувьцаа авсан тухай мэдээллийг нэмээд тайлбарлаад өгчихье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн ээ, түр хүлээж байгаарай. Та дараа нь тодруулаад асуугаадах.

Сая Т.Энхтүвшин гишүүн асуулт асууж байсан. Д.Батлут гишүүний ахалж байгаа ажлын хэсэг чухам ямар чиглэлүүд дээр ажиллаж байгаа юм? Энэ талаараа тодорхой яриад.

Дээрээс нь, Ш.Адъяаа гишүүний оруулж ирж байгаа энэ асуудалтай та нарын ажиллаж байгаа энэ ажлын хэсэг бас давхцаж байгаа юмнууд байна уу?

Энэ дээр мэдээллээ өгнө үү.

Д.Батлут гишүүний микрофоныг нээе.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын нэр бүхий гишүүд “Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай”, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс өргөн мэдүүлсэн “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хамтатган хэлэлцэх асуудлууд яригдаж Эдийн засгийн байгууллагаас ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа.

Энэ ажлын хэсэг дээр бид төрийн өмчийн компаниудын үр ашиг, менежментийг сайжруулах гэдэг чиглэл дээр олон нийтийн оролцоотой болох асуудлыг нэлээн чухалчилж үзэж байгаа.

Энэ дээр тухайлах юм бол төрийн өмчийн компаниудыг тодорхой хэмжээгээр ангилаад, үйл ажиллагаагаа зорилго, чиглэлүүдээр ангилаад, түүнд нь тохирсон тодорхой менежментүүдийг оруулж өгөх тал дээр санал гаргаад ажиллаж байна.

Энэ дотроо бас стратегийн өрсөлдөх чадвар бүхий аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулах дээр олон нийтийн оролцоог түлхүү болгох. Тэр дундаа 49 хүртэлх хувийг иргэдэд эзэмшүүлэх асуудал. 49 хүртэлх хувийн хувьцаа гээд иргэдэд эзэмшүүлэх асуудлуудыг бид бас ярилцаж санал болгож оруулахаар төлөвлөж байгаа юм.

Энэ дотор олон асуудлуудыг хөндөж байна.

Тухайлах юм бол саяын Ш.Адъяаа гишүүний оруулж ирээд байгаа 2010-2012 онд сургалтын төлбөр хэлбэрээр иргэд хувьцаагаа худалдсан асуудал, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн үйлчилгээ авах чиглэлээр бас иргэд хувьцаагаа зарж борлуулсан асуудлуудыг хэрхэх вэ гэдэг асуудлыг ажлын хэсэг дээр ярилцаж тухайн шийдлүүдийг гаргахаар бас ажиллаж байна.

Нөгөө талдаа “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа 2012 оны 4 дүгээр сарын 11-нээс өмнө төрсөн иргэдэд хамааралтай болчхоод байгаа.

Тэгэхээр түүнээс хойш төрсөн 900, сая орчим хүүхдийн асуудлыг хэрхэх вэ гээд.

Үндсэндээ Ш.Адъяаа гишүүний санаачлаад байгаа тогтоолын төсөлтэй холбоотой асуудал ч гэсэн манай энэ ажлын хэсэг дээр яригдаж, тодорхой шийдэл болж орж ирэх гэж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Тэгэхдээ нөгөө талаараа зөвхөн энэ “Эрдэнэс Тавантолгой” компанитай холбоотой асуудал биш.

Төрийн өмчийн бүхий л компаниуд, тэр дундаа стратегийн өрсөлдөх чадвартай аж ахуйн нэгжүүд дээр олон нийтийн оролцоог чухалчилж үзэх, иргэдэд хувьцаа хэлбэрээр олгох энэ боломжуудыг судалж, ирэх долоо хоногт Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр бэлдээд явж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн тодруулж асууя. Т.Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

Т.Энхтүвшин: Тэгээд Ш.Адьяаа гишүүн яах вэ, үүнийг өгөх, өгөхгүй асуудал яриагүй л дээ, би.

Тэртээ тэргүй юу гэдэг юм төрийн өмчтэй компаниудын менежментийг сайжруулах, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, олон нийтийн болгох асуудал дээр ажлын хэсэг гараад ажиллаж байхад үүнийг дангаар нь оруулж ирэх шаардлага байхгүй. Хамтад нь, төрийн өмчтэй, орон нутгийн өмчтэй бүх компаниудын асуудлыг ажлын хэсэг гарч байгаа юм чинь түүн дээр нь хамтатгаад оруулаад ирвэл илүү их үр дүнтэй юм биш үү.

Тийм учраас буцааж татаж аваад Д.Батлут гишүүн рүү өгөөд, энэ саналуудаа. Д.Батлут гишүүний ажлын хэсэг дээр зангидаад, ингээд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрийн өмчтэй компаниуд дээр л оруулаад ир гэж хэлсэн юм.

Тэгэхээр үүнийг дангаар нь оруулаад ирэх юм бол энэ чинь харин өрөөсгөл болох байгаа юм.

Одоо бид Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг яах юм, Монголросцветмет нэгдлийг яах юм, Хөтөлийн цемент шохойг яах юм, Багануурын уурхайг яах юм.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн санал хэлчихлээ.

Н.Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Асуудлыг дэмжиж байгаа юм. Ш.Адьяаа гишүүний оруулж

ирсэн энэ асуудал маш ноцтой асуудал л даа.

Яагаад гэхээр 1072 хувьцаа “Эрдэнэс Тавантолгой”-н асуудлыг бид Монголын ард түмэн хэзээ үнэ цэнтэйгээ мэдсэн бэ гэхээр нүүрсний энэ их хулгай, луйврын ард ямар их үнэ цэнтэй хувьцааг эзэмшдэггүй байсан юм бэ гэдгээ иргэд ойлгож эхэлсэн.

Тэгээд иргэдийн энэ ойлголт байхгүй үед нь энэ асуудлыг оруулж ирж сонгуулийн өмнө тэтгэврийнхэн, оюутнуудад иргэдийн хувьцааг мөнгөжүүлээд тараасан асуудал нь ер нь луйврын шинж чанартай асуудал шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлыг засаж залруулах нь уг нь энэ Их Хурлын болон Засгийн газрын зайлшгүй хийх үүрэг л дээ.

Ер нь Монголын ард түмэн. Түрүүн хэллээ. Энэ хулгай луйврын ард ямар их үнэ цэнтэй хувьцаа эзэмшдэгээ мэдсэн. Өнөөдөр зөвхөн “Эрдэнэс Тавантолгой” гэхэд **17 их наядын “оффтейк”** гэрээг хийчихсэн байгаа шүү дээ.

Одоо аягүй бол 8, 9 их наядын худалдан авалтыг ямар нэгэн хяналтгүйгээр зөвхөн дарга нарын томилсон компанийн захирлууд энэ худалдан авалтыг хийчихсэн.

Иргэдийн хяналтыг болохоороо энэ асуудалд оролцуулдаггүй. Иргэдийн тэр хянах эрхийг нь хаачихсан асуудал байгаа байхгүй юу.

Тэгэхээр иргэд өөрсдийнхөө хувьцааны үнэ цэнийг мэдэрсэн энэ цаг хугацаан дээр ижил тэгш боломжийг нь олгох нь зайлшгүй хэрэгтэй. Тэгж байж

өнөөдөр энэ ямар үнэ цэнтэй хувьцаа эзэмшиж байгаагаа мэдэрч байгаа байх.

Ер нь бид хувьцаа ярингуут манай иргэд маань шууд ногдол ашгаа авах талаар бодоод байгаа л даа.

Харамсалтай нь тийм боломж байхгүй гэж ойлгоод байгаа. Энэ дээр Эрдэнэс Тавантолгойнгийнхон хариулна биз.

Энэ “оффтейк” гэрээнүүдийн үр дүнд иргэд маань энэ 1072-ын хувьцааны ногдол ашгийг хэдэн жилээр авах боломжгүй болчихсон юм бэ? Хэдэн жилээр.

Өнөөдөр дандаа ирээдүйд өөрсдийнхөө байгаа хөрөнгөө барьцаалаад зээл авчихсан гэсэн үг шүү дээ. Шууд утгаар нь хэлэх юм бол. Энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ.

Тэгээд ер нь ямар нэгэн асуудалтай үүнийг холбож хэрэггүй. Энэ тогтоолын төслийг уг нь дангаар нь явуулбал илүү үр дүнтэй. Тэгээд олон ингээд нэг ийм мөнгөтэй холбоотой асуудлуудтай холбочихоор энэ чинь ингээд мөнгөн дүн нь өөрөө их болоод. Хоёрт нь, энэ асуудал бас тэр олон асуудал дундаа ороод живчихнэ.

Тийм учраас Ш.Адъяаа гишүүн минь энэ асуудлыг ер нь дангаар нь оруулаад. Үнэхээр эх оронч, иргэдийнхээ төлөө санаа зовниж байгаа тэр гишүүд энэ асуудлыг дэмжих, үгүйг нь харах хэрэгтэй л дээ.

Тэгээд тэгж байж энэ асуудал явна л даа. Түүнээс биш өөр олон төрийн өмчит компаниудын үйл ажиллагаануудын асуудлууд, өөр асуудлуудтай үүнийг зэрэгцүүлээд явах

юм бол энэ өөрөө асуудал дундаа ороод живчих юм харагдаад байна.

Ц.Цэрэнпунцаг: Н.Ганибал гишүүн нэг асуулт асуусан.

Ажлын хэсгээс Эрдэнэс Тавантолгойнхон хариулах уу? Ажлын хэсгийн 7 номерын микрофоныг нээе.

Г.Гантулга: “Эрдэнэс Тавантолгой” компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга. Гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Тавантолгой” дээр одоо нийтдээ 4.9 тэрбум ам.долларын төсөвт өртөгтэй 11 том төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа.

Нүүрс баяжуулах үйлдвэр, төмөр замын төслүүд, Тавантолгой дулааны цахилгаан станц зэрэг.

Тэгээд эдгээр төслүүдээс одоогийн байдлаар 1.5 тэрбум доллар орчмыг нь санхүүжүүлээд байж байгаа.

Төмөр замын төсөл, нүүрс баяжуулах үйлдвэр, газрын тосны хоолойн нийт “оффтейк” гэрээний төсөвт өртөг 1.7 тэрбум орчим байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Уул уурхайн сайд Ж.Ганбаатар гүйцээж хариулъя.

Ж.Ганбаатар: Энэ Засгийн хурлаар орсон юм. Засгийн хуралдаанаар ороод засаг дэмжээгүй.

Тэгээд гол шалтгаан нь “Эрдэнэс Тавантолгой” компани өнөөдөр 3.2 их наядын өртэй байгаа. Ямар их өртэй байгааг та. Н.Ганибал гишүүн бас гол гол зүйлүүдийг хэлж байна л даа.

Тэгээд энэ компани саяын хэлж байгаа тэр хоёр, гурван төсөл байгаа. Тэр төмөр замын холболт болоод тэр нүүрс боловсруулах асуудал. Ядаж угаагаад гарах асуудал. Тэгээд усны асуудал. Тэр угаах үйлдвэрээ хийхийн тулд усны асуудал шийдвэрлэх ёстой.

Үүнийгээ ядаж хийсний дараа тэр хувьцаа болоод хувьцааны ногдол ашиг олон зүйлүүдийг ярих нь яг тэр хувьцаа эзэмшигчид нь өөрт нь ашигтай.

Тэгэхгүйгээр тэгээд өнөөдөр нэг юу гэдэг юм 100 мянган төгрөг гэдэг юм уу, 90 мянган төгрөг гэдэг юм уу, ийм байдалтай. Хувьцаа эзэмшигчдийн ирээдүйд өөрт нь ашиггүй. Өөрт нь ашиггүй байхгүй юу.

Тэгэхээр өөрт нь, хувьцаа эзэмшигч нарт ашигтай байлгахын тулд Засгийн газраас энэ холболтынхоо ажлыг яаралтай хий, энэ боловсруулалтынхаа ажлыг яаралтай хий гэдэг ийм даалгавар өгч байгаа.

Уул уурхайн яамнаас ч гэсэн тэр. Энэ хуралд Ж.Ганбат дарга суух ёстой л доо. Саяын энэ асуултад хариулах ёстой хүн нь шүү дээ. Энэ шинэ дарга сая л томилогдоод их удаагүй байгаа байх.

Тэгэхээр гол зүйл тийм байна. “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьд сайн ажиллаж байгаа. Сая Н.Ганибал гишүүн сайн үнэн бодитыг нь хэлж байна л даа. Тэнд ямар хулгай, ямар хүнд суртал, ямар хээл хахууль нүүрлэсэн байсан. Тэрийг Засгийн газар яаж шийдвэрлэсэн.

Тэгээд өнөөдөр нүүрсний гаралт бараг 61 сая тоннд хүрч байна шүү дээ.

Үүний бараг талыг нь. Ойролцоогоор 42, 43 хувийг нь Эрдэс Тавантолгой гаргаж байгаа. Дангаараа.

60, 70 хувийг нь бараг Эрдэс Тавантолгой компани биржийн үйл ажиллагаанд зарж байгаа.

Тэгээд энэ компанийн тэр хувьцаа эзэмшигчид нь ашигтай байлгах үүднээс л энэ хөрөнгө оруулалтаа хурдан гүйцээх ёстой, энэ өр төлбөрөө барагдуулах ёстой гэдэг ийм шийдвэрийг засаг гаргасан гэдгийг Н.Ганибал гишүүн хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Ш.Адъяаа гишүүн хариулах уу? Нэмж хариулах уу? Ш.Адъяаа гишүүний микрофоныг нээе.

Ш.Адъяаа: Яах вэ, Эрдэнэс Тавантолгойг өртэй, өргүй байлгах асуудал Монголын 3 сая хүний асуудал биш ээ. Үүнийг удирдаж зохион байгуулсан төрийн л асуудал.

Иргэд, хувьцаа эзэмшигч нар энэ компанийг өр ширэнд унагаагүй гэдгийг хариуцлагатай хэлье.

Ер нь яах вэ, энэ асуудлыг шийдэх нь өнөөдөр төр, засгаас ард иргэд шаардаад байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасан баялагтай эзэн байя. Дээр нь төрийн өмч, байгалийн баялагтаа ард түмний хяналтыг сайжруулья. Монголын төр иргэн бүрд өмч хөрөнгөтэй байя гэдэг энэ зарчим.

Түүнчлэн сонгууль бүрийн өмнө ард түмнийхээ хувьцааг мэдээлэлгүй, дээр нь хөрөнгө мөнгөний чадваргүй, тэтгэврийн насны, оюутнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мөнгө төгрөг байхгүй байдлыг далимдуулж төрөөс

хувь хүртээсэн, байгалийн баялгийг хүүртээсэн тэр хувьцааг сонгууль бүрийн өмнө луйвардаж авсан энэ юмыг бас нэг засаж залруулчихъя.

Тэгээд ард түмний өмч хөрөнгөтэй болчихъё. Энэ дээр ямар нэгэн тийм хувьцаа эзэмшигчдийг, Засгийн газрыг өрөнд оруулна гэсэн асуудал байхгүй шүү дээ. Бид 2019 онд анх удаа ногдол ашиг гэж нэг хувьцаанд 93 мянган төгрөг өгсөн байгаа.

Тэгэхээр энэ ногдол ашгаас нь үүнийг суутгаж аваад л явчихъя гэж байгаа юм. Хэлэлцэх эсэхийг нь шийдчих ээ.

Тэгээд би Д.Батлут нарын 5 гишүүний өргөн барьсан тэр төрийн өмчийн өмчийн компаниудын менежментийн асуудал, түүнчлэн энэ хувьцааны асуудал, төрийн өмч өмчийн компаниуд дээрх засаглалын асуудалтай холбогдуулсан тогтоолын төсөлд нэгтгээд явъя л гэж байгаа юм.

Би үүнийг эсэргүүцээд байсан байхгүй. Ийм учраас энэ асуудлыг та нар Улсын Их Хурлынхаа хууль батлах бүрэн эрхийнхээ хүрээнд шийднэ биз.

Ер нь тэгээд ард түмнээ өмч хөрөнгөтэй байхын эсрэг, сонгууль бүрийн өмнө луйвардаж авсан, иргэдийгээ төөрөгдүүлсэн тэр юмыг тэр засаад, цаашлаад үүнийг иргэн бүр өмч хөрөнгөтэй байчихъя.

Төрийн өмч хөрөнгө дээр ард түмнийхээ хяналтыг Монголын 3 сая иргэний хяналтыг тогтооё л гэж байгаа юм.

Түүнээс биш энд өөр надад санаа зорилго байхгүй ээ. Тэгэхдээ энэ асуудлыг Эрдэнэс Тавантолгойн

удирдлагууд Н.Ганибал гишүүний асуудалд нэмж хариулт өгөх байх гэж бодож байна.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Ганбаатар сайд гүйцээж нэмж хариулъя. Ж.Ганбаатар сайдын микрофоныг нээе.

Ж.Ганбаатар: Ш.Адъяаа гишүүн ээ, тийм луйвардсан юм байхгүй.

Харин ч засаад, залруулаад явж байгаа.

Н.Ганибал гишүүн сая хэллээ шүү дээ.

Засгийн газар засаад залруулаад бараг энэ чинь 5 гаруй их наядын өртэй байсан бол өнөөдөр 3.1. Нэг жилийн дотор шүү дээ. Өртэй болгож багасгасан.

Бүх зүйл нь ил тод байгаа. БЭТ_[бүтэн эрхт төлөөлөгч] ГЭЭД хүн тавигдсанаас хойш энэ компанийн үйл ажиллагаа харин ч гэж Монголын Улсын эдийн засагт маш том үр нөлөө өгч байгаа.

Тэгээд хувьцаа эзэмшигчдийн ирээдүйн эрх ашгийг бодож л тэр хөрөнгө оруулалт гэдэг зүйл орж байгаа шүү дээ.

Өнөөдөр өгчихвөл тэр ирээдүйд олох. Өнөөдөр 100 мянган төгрөг үү, ирээдүйд боломжийн ашиг уу гэдэг зүйл л сонголт байхгүй юу. Өнөөдөр бүгдээрээ 100 мянган төгрөгөө авчихъя. Тэр төмөр замын холболт хамаагүй, боловсруулах үйлдвэр хамаагүй гэдэг утгаар хандахгүй байхыг л хүсэж байгаа юм.

Тэгээд үгээ бас нэг жоохон соёлтой сонгоорой гэж. Та бас түрүүн нэг гишүүнд хэлнэ лээ. Би таныг бас сонголттой сонгоорой гэж хэлье.

Уучлаарай. Би ярьж дуусаагүй байгаа. Таныг ярьж байх хооронд би юм яриагүй.

Тэгээд “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьд үнэхээр. Би одоо зүгээр яг практик л хариулж байгаа юм.

Үнэхээр өмнөх экспорт нь ямар байсан юм, өнөөдөр ямар экспорттой байна. Дахин дахин дурдаад баймааргүй байна. Монгол Улсын эдийн засагт оруулж байгаа тэр долларын юу ямар байна. Хэдэн тэрбум доллар яг Монголд ороод ирсэн юм.

Тэгээд энэ компани нь өөрөө хариул л даа. Намайг хариулахаар яг улс төрч гэж гэдэг үүднээс хандаад байдаг юм л даа.

Тэгэхээр бараг 1.8 тэрбум доллар оруулж байгаа шүү дээ. Жилийн дотор. Тэгээд улсын төсөвт бид татвараар бүрдүүлж байгаа татварын орлого байгаа. Тэгээд энэ компани чинь өөрөө засраад явж байгаа.

Тэгэхээр энэ засраад явж байгааг нь цааш нь хөрөнгө оруулалтынх нь ажлыг нь дэмжээд ирээдүйд хувьцаа эзэмшигчдээ олох одоо тэр ногдол ашгийг нэмэгдүүлэхийн төлөө Засгийн газар бүх чадлаараа ажиллаж байна. Энэ дээр дэмжлэг болж ажиллахыг л хүсье.

Дундаас нь орж ирээд тэрийг нь ингэмээр байна, үүнийг ингэмээр байна гэвэл ирээдүйд энэ компани төмөр замынхаа холболтыг хийж нүүрсээ гаргах ёстой. Ш.Адышаа гишүүн ээ, угааж боловсруулж байж гаргах ёстой. Энэ үнэхээр зөв төсөл байна. Үүнийг нь ил тод болгоод дэмжээд явах дээр нь л хамтран ажиллаарай л гэдгийг хэлье. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Н.Ганибал гишүүн тодруулж асууя.

Н.Ганибал: Миний асуугаад байгаа асуултын гол санаа нь ийм байхгүй юу.

Өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” маш олон “оффтейк” гэрээнүүдийг санхүүжүүлж байна. Энэ “оффтейк” гэрээнүүд эргэж хэзээ ашиглалтад орох юм? Тэгээд тэндээсээ хэзээ ашгаа өгөх юм?

Дээрээс нь, өнөөдрийн “Эрдэнэс Тавантолгой” компанийн жилдээ олборлож байгаа олборлолтын хэмжээ хэдийгээр нэмэгдэх юм?

Хэзээнээс эхлээд энэ компани ашигтай ажилладаг болоод тэгээд иргэддээ ногдол ашиг өгдөг болох юм бэ?

Энэ талаар энэ компанийнхан ямар нэгэн эдийн засгийн тооцооллууд хийсэн үү?

Эргэж бас нууцаар гэрээнүүд хийх гээд байна уу?

Тийм учраас ямар ч компани ирээдүгээ төлөвлөнө шүү дээ. Тийм үү? Энэ төсөөлөлдөө энэ хувьцаа эзэмшигчдээ бодит үнэнийг хэлээд өгөөч ээ гээд хэлээд байгаа байхгүй юу.

Ц.Цэрэнпунцаг: Н.Ганибал гишүүний асуултад түрүүн 7 номер дээрээс тэр Хөрөнгө оруулалтын газрын дарга байсан. Яг бизнес төлөвлөгөөгөө хэлээдэх.

Шинэ гүйцэтгэх захирал төлөвлөгөөгөө. Энэ ямар хэмжээний хөрөнгө оруулалтууд хийж байгаа юм. Үүнийгээ хэдэн жилийн хугацаанд яаж нөхөх юм бэ. Хэзээнээс хашаа дивидент

хуваарилдаг болох юм бэ л гэсэн асуулт асуусан. Тодорхой хариулаарай. 5 номерыг нэе. Ажлын хэсгийн 5 номер.

Х.Мөнхжаргал: Сайн байцаана уу? Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. “Эрдэнэс Тавантолгой” Компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал байна.

Оффтейк гэрээнүүдийн хувьд анх онцгой дэглэм тогтооход нийтдээ 4 төсөл, хөтөлбөртэй холбоотой 38 оффтейк гэрээ байсан. Үүнээс гэрээг хугацаагаар нь дуусгаад одоо нийтдээ “Эрдэнэс Тавантолгой” компани дээр 3 төсөлтэй холбоотой 3 ширхэг оффтейк гэрээ л байгаа.

Энэ нь төмөр зам, Гашуунсухайт, нүүрс баяжуулах үйлдвэр, газрын тосны үйлдвэр гэсэн 3 төсөлтэй холбоотой 3 оффтейк гэрээ зогсоогүй ажиллаж байгаа.

4 төслийн 1-ийг нь зогсоосон. Богд хаан төмөр замын төслийг зогсоогоод байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн одоо хэрэгжүүлж байгаа төслүүд уурхайн тоног төхөөрөмжийн төсөл, конверын төсөл, баяжуулах үйлдвэр, Загийн-Ус, Загийн-Усны хоолой. Тэгээд газрын тос, Тавантолгой, Гашуунсухайт төмөр зам, Зүүнбаян гэдэг төслүүд ерөнхийдөө гүйцэтгэл их өндөр хувьтай явж байгаа.

Энэ дундаа Загийн-Усны хоолойн төсөл ерөнхийдөө эцэслэж байгаа. Тавантолгой, Гашуунсухайт төмөр замын төсөл гүйцэтгэл ерэн хэдэн хувьтай явж байгаа.

Одоогоор ашиглалтад бүрэн ороод ашиглаад явж байгаа төсөл яг одоогоор

байхгүй байгаа. Тавантолгой төмөр замын төсөл ерөнхийдөө явж байгаа.

Тэгэхдээ бүрэн ашиглалтад өгөөгүй байгаа.

2022 оны компанийн ашиг **1.3 их наяд** төгрөгийн цэвэр ашигтай гарсан. Хэрэв ногдол ашиг тараах тохиолдолд иргэдийн эзэмших хувь **240.0 тэрбум**, төрд ноогдох хувь **1 их наяд**. Хэрэв 100 хувь ногдол ашиг тараасан тохиолдолд хуваарилагдахаар байгаа.

Яах вэ, компанийн үндсэн бодлого энэ ногдол ашгийн хувьд түрүүн Ж.Ганбаатар сайд хэлсэн.

Ер нь “Эрдэнэс Тавантолгой” компанийн өмнө үүссэн байсан өр төлбөрийг бид **4.9 их наяд** байсныг одоо бууруулаад **3.1 их наяд** болгосон.

Мөн төслийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр бид дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийснээр ашигт ажиллагааг дээшлүүлээд, түүнийхээ үр дүнд бид ногдол ашиг хуваарилбал хүртэх өгөөж маань бас дээшлэх өндөр юутай байгаа.

Мөн компанийн үндсэн байр суурь тооцооллоор нэгж хувьцаанд ногдох ашиг 2022 оны ногдол ашгийг хуваарилсан тохиолдолд 108 мянган төгрөг. Нэг нэгж хувьцаа. 1072 хувьцаатай нэг иргэнд нийт ногдох ашиг нь 116 мянган төгрөг гэсэн урьдчилсан тооцоолол гарсан байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Тодорхой хариулсангүй шүү.

Засгийн газрын гишүүн эндээс тайлбарласан. Ямар байр суурьтай байгаа юм бэ гээд. Тэгээд гол хөрөнгө оруулалтуудаа удаан хугацаандаа үр өгөөжөө өгч хувьцаа эзэмшигчдийн

хувьцааг үнэ цэн оруулах, цаашдаа удаан хугацаандаа өндөр дивидент хуваарилах боломж бүрдүүлэх тэр хөрөнгө оруулалтуудыг хийж байгаа гэж асуусан.

Тэгэхээр энэ дээр нь тодорхой та нар хэзээ, хэдэн жилийн дотор төслүүдэд хөрөнгө оруулалт хийгээд дуусах юм. Тэгээд үр өгөөж нь ямар байх юм гэдэг дээр л уг нь хариулчихвал зүгээр байсан юм.

Тэгээд дараа бас боломж гарвал энэ дээрээ тодруулж хариулаарай.

М.Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Манай дарга нарын үг, үйлдэл хоёр хэрвээ биелдэг бол яг өнөөдөр 2023 оны 11 сарын 28-ны өдөр Эрдэнэс Тавантолгойн төлөөлөн удирдах зөвлөл хуралдаад бас ашигтай ажилласан байна.

Энэ 1072 ширхэг хувьцааны ногдол ашиг тараах эсэхийг шийднэ гээд яг одоогоос 3 сарын өмнө хэвлэлийн бага хурал дээр мэдэгдэж байсан л даа.

Яг өнөөдөр 11 сарын 28-ны өдөр. Хуультай, хуульгүй ашигтай ажилласан л бол иргэдийнхээ ногдол ашгийг бид хуваарилах ёстой.

Гэхдээ бэлэн мөнгө тараа гэсэн үг биш. Бид дансыг нь үнэт цаасны ч юм уу, янз бүрийн арга хэлбэрийг ашиглаж болно л доо.

Энэ асуудлыг хууль оруулж ирээд шийдэх гээд ч байгаа юм биш. Жишээ нь, би бүр 9 сард хэлж байсан. 1072 ширхэг хувьцаа. Бид чинь 1.3 их наядын ашигтай ажиллаж, валютын нөөц 1 тэрбум доллароор нэмэгдээд. Өнөөдөр бид

төсвөө хүртэл нэлээд сайн тэлж баталж байна шүү дээ.

Гэтэл иргэд маань 1072 хувьцаагаа, тэр дундаа яг бүтэн эзэмшдэг сая 80 мянган хүн маань миний хувьцаа өнөөдөр 106 төгрөгөөр нэмэгдээд 116 мянган төгрөг болсон юм байна гээд мэдээд. Энэ маань миний дансанд юм уу, миний банканд суутгагдаад явж байна гэж бодож байх ёстой шүү дээ. Тооцоолж байх ёстой.

Одоо тэгээд жижиг Тавантолгой, том Тавантолгой, нүүрс тээвэр гээд л хэдэн тэрбумаар нь хулгай хийгээд л байгаа хэрнээ иргэдийнхээ 1072 хувьцаа дээр болохоор өр төлбөрийг нь төлснийхөө дараа болно, ийм болно гээд элдэв юм яриад суугаад байхаа ичих хэрэгтэй шүү дээ манай зарим нэг хүмүүс.

Д.Батлут гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гарчихсан байгаа. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бид яриад 1072 ширхэг хувьцааг иргэд ашигтай ажиллаж байгаа тохиолдолд бас үүнийгээ ТУЗ нь хуралдаад шийдвэрээ гаргах ёстой гэдгийг хэлсэн. Бид шийдвэрээ гаргана гээд. Тэгээд 11 сарын 28-ны өдөр хуралдана гэж байсан л даа.

Одоо энд ТУЗ-өөс нэг ч хүн байхгүй байна уу? Би шинэ гүйцэтгэх захирал Х.Мөнхжаргал даргаас асууя.

Нэгэнт ашигтай ажилласан байна шүү дээ. Та нар сая хэлж байна. 4.9 их наядын алдагдалтай байсныг бид 3.7 болгож алдагдлыг бууруулсан байна. 1.3 их наядын цэвэр ашигтай ажилласан байна.

Та бүхэн минь валютын нөөцөө өсгөхөд нөлөө үзүүлж байна. Бид нүүрсний хулгайн дээр Л.Оюун-Эрдэнэ

Ерөнхий сайд сайн тэмцэж байна шүү дээ.

Би өөрөө бас энэ Нүүрсний сонсголын ажлын хэсгийн гишүүн.

Нэг талаас бид хулгайг зогсоож байна. Нөгөө талаасаа цэвэр ашигтай ажиллаж байна. 1.3 их наядын гэж байна.

Иргэдийнхээ 1072 хувьцааг Та бүхэн ямар ч байсан ногдол ашгаа одоо энэ 2022 оны тайлан гарангуут 2023 онд ингэж оногдуулах юм байна.

Үүнийгээ он гарч байгаад бүгдээрээ өгөөч гэдэг юм уу. Яг ингээд тодорхой баймаар байна.

Түүнээс биш эдийн засагтаа хүндрэл учруулаад, үнэ ханш, инфляцыг өсгөх гээд байгаа юм биш шүү дээ.

2 сая 500 мянган иргэд маань хувьцаа эзэмшдэг. Үүний яг цэвэр эзэмшдэг нь сая 80 мянга. Засгийн газартаа борлуулсан сая 420-оод мянган хүн байгаа шүү дээ.

Тодорхой байхад Та бүхэн асуудлыг шийдчих хэрэгтэй байгаа л даа.

Түүнээс хууль санаачлаад явж байгаа юм биш шүү дээ. Энэ хууль аль эртний, угаасаа л ногдол ашгаа өгөх ёстой. Ашигтай ажиллавал өгөх ёстой. Алдагдалтай ажиллавал харин Засгийн газар тодорхой арга хэмжээг нь авах ёстой гэдэг ийм л дүрмээр бид явж байгаа шүү дээ.

Тэгээд би Х.Мөнхжаргал даргаас асууя.

Та бүхэн маань ер нь төлөөлөн удирдах зөвлөл хэзээ хуралдах вэ? Иргэддээ 1072 хувьцааны ногдол ашгийг

олгох эсэх асуудлаар шийд хэзээ гарах бол оо?

Та гүйцэтгэх захирлын хувьд энэ асуудлыг оруулах тал дээр хэр санаачилгатай ажиллаж байгаа вэ? Энэ дээр би хариулт авахыг хүсэж байна.

Тэгээд дараа нь тодруулья гэж бодож байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 5 номер. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал захирал хариулья.

Х.Мөнхжаргал: Гишүүнтэй миний хувьд санал нэг байна.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн төлөөлөн удирдах зөвлөл миний бие бас энэ асуудлыг уламжилъя.

Ногдол ашиг тараах эсэх асуудал дээр би гүйцэтгэх удирдлага учраас шийдвэр гаргах боломжгүй, шууд хариулах боломжгүй байна. Энэ бол компанийн тухай хуулиараа төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн асуудал байгаа.

Гэхдээ миний бие ямар ч байсан энэ асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн ойрын хуралдаа асуудал оруулж танилцуулья.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд асуулттай холбогдолтойгоор үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

М.Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Т.Энхтүвшин гишүүн үгээ хэлье.

Т.Энхтүвшин: Ж.Ганбаатар сайд сая тодорхой ярилаа даа.

Ер нь тэгээд бид цаашдаа иргэдийн 1072 хувьцааг өсөн нэмэгдүүлье, иргэддээ жоохон ахиухан мөнгө хувь хуваарилъя л гэж бодож байгаа бид энэ төмөр замын холболтын асуудлыг шийдэх хэрэгтэй, угаах үйлдвэрээ яаралтай бариад дуусгах хэрэгтэй, тэр Загийн хоолойгоос татаж байгаа усны асуудлаа шийдэх ёстой гээд.

Энэ том бүтээн байгуулалтаа явуулж байж л цаашдаа тогтвортой хувьцааны үнэ өснө шүү дээ.

Бид нарт нэг ийм хугацаа байгаа шүү. Ш.Адъяаа гишүүн ээ.

Бид түүхийгээр нь удаан жил зөөхгүй шүү.

Цаашдаа бид нүүрсээ үнэтэй болгоё гэж байгаа бол боловсруулаад, баяжуулаад, түүхийгээр нь зөөж байснаас хоёр дахин үнээр зөөх юм бол нөгөө иргэдэд оногдож байгаа хувьцааны чинь үнэ нь л нэмэгдэх юм.

Тийм учраас л энэ том бүтээн байгуулалтуудаа л яаралтай дуусгах хэрэгтэй. Ингэж байж цаашдаа “Эрдэнэс Тавантолгой” тогтвортой үйл ажиллагаа явуулах, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх, үнэтэй зарах, иргэд маань хувьцаанд ахиухан мөнгө авах бололцоо боломж бүрдэнэ.

Тийм учраас түрүүн яриад байдагтай адил төрийн өмчтэй компаниудынхаа асуудлыг Д.Батлут гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг дээрээ бүгдийг нь нэгтгээд, тэр Багануур, Шивээ-Овоо, Монголросцветмет нэгдэл, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хөтөлийн асуудал, энэ Эрдэнэс

Тавантолгойн асуудал, жижиг Тавантолгойн асуудлаа нэгтгээд нэг оруулж ирээд л энэ асуудлаа Байнгын хороон дээр ярих нь зөв байх л гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн үгээ хэлье.

М.Оюунчимэг: Би бас Т.Энхтүвшин гишүүнтэй санал нэг байна.

Сая Уул уурхайн сайд Ж.Ганбаатарын хэлдэг 1072 хувьцааг аль болохоор ашигтай, илүү өгөөжийг нь нэмэгдүүлье гэдэг маш зөв.

Бид мэдээж түүхийгээр нь гаргаад яваад байх юм уу, эсвэл энэ дээр улс төр хийгээд сонгууль болгоны өмнө шоудаад байх шаардлагагүй. Зогсоомор байна л даа. Бид маш их улс төржиж байгаа.

Тэгэхээр 2024 оны улсын төсөв дээр мэдээж бид төмөр замын холболт, усны асуудал, өөрсдөө энэ эрчим хүчээ хангадаг байх гээд олон асуудлууд дээр **100 том төсөл** хэрэгжүүлье.

Энэ төслийн хүрээнд ханган нийлүүлэх чиглэлийн төслүүдээ аваад явъя гээд бас тодорхой томоохон төсвөө суулгасан байгаа.

Энэ ажил хурдтай, эрчимтэй явж чадвал 1072 ширхэг хувьцааны үнэ нэмэгдэх нь тодорхой.

Тэгэхээр энэ том зүйлүүдээ бид том хүрээндээ хараад бодлогоо хурдан хэрэгжүүлээд явчих хэрэгтэй байх.

Харин би гүйцэтгэх захирал болон “Эрдэнэс Тавантолгой”-н багийнханд хэлэхэд Та бүхэн цэвэр 1.3 их наядын ашигтай ажилласан байна.

Ямар ч байсан ногдол ашгаа иргэддээ хүртээх, хуваарилах тал дээр санаачилгатай ажиллаарай гэж хүсэх байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье. Томьёоллыг уншиж танилцуулъя.

“Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

30.8 хувиар гишүүд дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулна.

“Иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

Эдийн засгийн Байнгын хороо нь хорооны өнөөдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье.

Ингээд хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 49 минут үргэлжилж, 12 цаг 21 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД